**ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ..11.. ДҮГЭЭР**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 15 өдөр Дугаар 45 Мөрөн сум

Сумын засаг даргын 2025 оны үйл ажиллагааны
Хөтөлбөрийн биелэлтийн тайлан
хэлэлцсэн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1,2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг "Үр дүн гарсан" гэж дүгнэсүгэй.

2. Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг хавсралтаар баталсугай.

ДАРГА Ж.ДАШЖАМЦ

1825020010
9076077 CBT27306

*D:/ Hurliin togtool.doc-2025*

23130121б

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
12 дугаар сарын 15-ны өдрийн
Арваннэгдүгээр хуралдааны ..45...тогтоолын хавсралт

**Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт**

Мөрөн сум 2025 он

| № | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин |
|---|---|---|---|---|---|
| **НЭГ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | |
| **Бүсийн хөгжил** | | | | | |
| **1.1.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжинэ.** | | | | | |
| 1 | 1.1.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлд түшиглэн хөгжүүлнэ | 1.1.1.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | төлөвлөгөө батлуулсан байна | төлөвлөгөө байхгүй | Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн төсвийн 100 сая төгрөгөөр хийлгэхээр батлуулан тендер зарлан ДИ ТИ БИ ХХК 99 сая төгрөгний үнийн саналаар гэрээ байгуулж 2026 оны 09 сард ажлыг хүлээлгэж өгхөөр болсон. |
| | | 1.1.1.2. Хөдөө аж ахуйн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа байгуулах хувийн хэвшил, хоршоодыг дэмжих | Дэмжлэг үзүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээний тоо | | 2025 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд /тодотгол/-р 2025 оны 04-р сарын 04-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Мал аж ахуйн үйлдвэрлэл /шинэ хоршоо/ - 9 тус тус нэгж төлбөр батлагдсан. Төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж 9 хоршоонд 27 га газар эзэмшүүлсэн. 2026 оны ГЗБТЖТөлөвлөгөөнд мал аж ахуйн үйлдвэрлэл зориулалттай газар /шинэ хоршоо/ - 8 нэгж талбар буюу 22,5 га, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 7 нэгж талбар буюу 35 га газар хоршоодод төлөвлөн ажиллаж байна. |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | |
| **Гэр бүл, хүүхэд хамгаалал, хүн ам** | | | | | |
| **2.1.Гэр бүл болон нийгмийн орчин дахь хүүхэд хамгааламжийг сайжруулж, өсвөр үе, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | |
| 2 | 2.1.1. Засгийн газраас хэрэгжүүлж буй өсвөр үе, залуучуудын | 2.1.1.1. Улс, аймаг, Дэлхийн хэмжээний тэмцээнд оролцох, амжилт гаргасан | Улс, тив, дэлхийн хэмжээнд амжилт | 4 | Улсын аварга шалгаруулах Чөлөөт бөхийн тэмцээнд амжилттай оролцож хүрэл медаль хүртсэн Н.Уугангэрэлд 500 000 төгрөгийг дэмжлэг үзүүлсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ | залуучуудыг урамшуулна. | гаргасан залуучуудыг дэмжинэ | | |
| | | 2.1.1.2. Төрийн албанд ажиллаж буй залуу гэр бүлүүдэд чиглэсэн орон сууц, амины орон сууц барих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | Хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд | 0 | Төрийн албан хаагчдын 8 айлын байрыг ОНХСангийн 75 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их хаан групп ХХК засвар хийн хүлээлгэн өгсөн.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн төв -1, Цэцэрлэг, ЕБСургууль-1, ЗДТГазрын 6 албан хаагчыг байранд оруулаад байна. |
| 4 | 2.1.5. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын "Ирээдүйн ээзд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2.1.5.1. "Ирээдүйн ээзд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хэрэгжилтийн хувиар | | “Ирээдүйн ээзд хөтөлбөрийн хүрээнд” Сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулсан. 2025 төлөвлөгөөний хэрэгжилт 91,3 хувь. Нийт 23 ажил төлөвлөсөний 21 ажил хийгдсэн байна. |
| | | 2.1.5.2. Хүүхэд, гэр бүлийн өмнө үүрэг хүлээгчдийг чадавхжуулах, дэмжих | Хувиар | 1 | 04 сард Хүүхэд хамгааллын хамтарсан багийн чадавжуулах сургалтыг ИТХ болон Хэнтий аймгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Хамтарсан багийн 15 гишүүн, болон төсөв байгууллагын 85 албан хаагч хамрагдсан.<br>11 сард ИТХуралтай хамтран Төсөв байгууллагын 65 албан хаагчидад Хүүхэд хамгааллын тухай хуулийн гэр бүл, нийгмийн орчин дах хүүхэд хамгааллыг танилцуулах сургалтыг зохион байгуулсан.<br>Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан 3 удаа танхимаар, 8 удаа цахимаар мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.1.5.3. Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, хөгжлийг дэмжих ажлыг олон нийтийн оролцоотой хэрэгжүүлэх | Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тоо, Хамрагдсан хүүхдийн тоо, Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | 5 | Хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хөгжлийг дэмжих ажлын хүрээнд 03 сард “Хөвгүүдийн өдөр” санал хүсэлт сонсох өдөрлөг, 06 сард “Өртөөлөн аялж, хамтдаа баярлая” хүүхдийг өртөөлчлөсөн аялалын баяр, 11 сард “Охидын шивнээ” охидын санал, хүсэлтийг сонсох арга хэмжээнүүдийг сумын төсөв байгууллагууд болон Хүүхдийн элч, аж ахуй нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан байна. Нийт давхардсан тоогоор 388 хүүхэд хамрагдсан байна. Нийт 1965,0 мянган төгрөг зарцуулсан байна.<br>Амьжиргаа түвшин доогуур өрх толгойлсон, олон хүүхэдтэй өрхийн судалгааг гарган, хичээлийн хэрэгслийн багцыг 29 хүүхэд гардууллаа. Нийт 1518,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.<br>Хүүхдийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд сумын<br>Сумын сагс, волейбол дугуйлангийн сурагчидад 918,0 мянган төгрөгийн үнэ бүхий 10 ш бөмбөг, улсын шагай харвааны тэмцээнд оролцсон 7 сурагчидад замын зардал, мандатны үнэ 350,0 мянган төгрөг, аймгийн өсвөрийн үндэсний бөхийн барилдаан түрүүлсэн Г.Баянзулд 200,0 мянган төгрөгийг тус тус дэмжлэг үзүүлсэн байна.<br>Хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, гэр эргэлт, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 1800,0 мянган төгрөгийг зарцуулсан байна. |
| **ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ** | | | | | |
| **2.2. Халамжаас хөдөлмөрт шилжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.** | | | | | |
| 5 | 2.2.1. Нийгмийн халамжийн зорилтот өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулна. | | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | 15 | Ажил хайгч-31 иргэн үүнээс<br>1.Ажил олоход хүндрэлтэй-16 иргэн малчин- 6, зорилтот бүлгийн- 9 нийт 31 иргэнд ажлын чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгч Ejob программд бүртгэв<br>2.Политехникийн коллежийн Хүнсний ногоо тариалалт Хүлэмжийн аж ахуйн мэргэжил олгох сургалтанд зорилтот бүлгийн 4 иргэн хамрагдаж төгссөн.<br>3."Хөдөлмөрт бэлтгэх сургалтанд 30 иргэний хамруулж мэдээлэл хүргэсэн. Сургалтын багшаас 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэж байгаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | болон эрхлэхээр төлөвлөж байгаа иргэдэд ганцаарчлан мэдээлэл. зөвлөмж авсан. |
| 6 | 2.2.2. Хувийн хэвшил, ТББ-ын оролцоотой / ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн / иргэдийг дэмжиж ажиллана. | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | 1 | Малжуулах хөтөлбөр 2 өрхийн 4 иргэний ажлын байранд 16,000,0 төгрөг, ХБ-тэй 1 өрхийн 2 иргэний ажлын байранд 4,500,0 төгрөг, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байр 2 ахмадад 7,000,0 төгрөг, Иргэний ажлын байрны дэмжих хөтөлбөрт 2 иргэнд 15,000,0 төгрөг нийт 10 иргэний ажлын байрыг дэмжиж 42,500,0 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажиллах ажлын хүрээнд 20,000,000 төгрөгийн "Хог пресслэгч"машиныг хүлээн авлаа. 2-3 иргэн ажлын байраар хангагдах нөхцөл боломж бүрдлээ. Мөн арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулахад бэлэн болгож байрыг засварласан. Ажлын байр зарлагдсан. |
| 7 | 2.2.3. Төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан байнгын болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ. | Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо | 3 | Ажлын байрны зар мэдээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэн ажиллаж байна.<br>Бэрх-Уул ХК -д жолоочоор - 2.<br>Галчаар -2, үйлчлэгчээр -1<br>Сумын Уурын зууханд - галчаар 2 . М-Агрод үйлчилгээний ажилтнаар-3.<br>Түр ажлын байр - Хадлангийн ажилд туслах ажилтнаар зорилтот бүлгийн 8 иргэн, Аялал жуучлалыг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд 5 өрхийн 10 иргэнийг Гэр камп-н үйл ажиллагаа явуулах түр зөвшөөрөл олгосон суманд байнгын болон улирлын чанартай ажилд орсон 30 иргэний мэдээллийг EJOB - программд бүртгэн баталгаажууллаа. |
| 8 | 2.2.4. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга | 2 | Суманд үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, ААН-н ажилтан, албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийг сурталчлан ажилласан. Нийт 50 иргэн хамрагдсан. Мөн төсөвт байгууллагуудын ХАБ-ын ажилтнуудад зөвлөмжийг 2 удаа өгсөн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээний тоо | | |
| 9 | 2.2.5 Хүнсний эрхийн бичгээр үйлчлүүлдэг иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, ХЭБ-ээр үйлчлүүлдэг иргэнгүй сум болно. | | ХЭБ-ээр үйлчүүлдэг өрхийн тоогоор | 6 өрх | Хүнсний эрхийн бичиг олгох журмын 4.12 дахь заалт ,1,5,3 , 5.2.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2 өрхийг АДЗ-ийн шийдвэрээр үйлчилгээг зогсоосон. 2025 оны 12-р сарын байдлаар 5 өрхийн 31 иргэнд 3.168.000 төгрөгийн ХЭБ-ийн үйлчилгээг олгон хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Нийтийг хамарсан ажилд 4 иргэнийг хамруулж хүнсний ногооны хашаа тойрсон хур хогийг цэвэрлүүлэх ажлыг хийсэн. |
| 10 | 2.2.6. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх, хөгжлийн төвийн үйл ажиллагаа тогтмолжуулна. | | Арга хэмжээний тоо,хамрагдсан иргэдийн хувь /сумын нийт хүн ахмадын тоо/ | 70 | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх, соёл урлагийн авьяас чадварыг нь хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:<br>- Аймгийн Ахмадын спортын наадамд 20 ахмад оролцоход - 1,000,000<br>- Хөдөлмөрч Манлай ахмадад 300,000 төгрөг<br>- Ахмадын урлагын бага наадамд -35 ахмад -1.000.000<br>2. "Ахмадын баяр 2025" арга хэмжээнд нийт 120 гаруй ахмадууд тус тус оролцсон.<br>Соёлын төвийн 1 өрөөг ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулж тохижуулахаар тохижилтын ажил хийгдэж байгаа. |
| **НИЙГМИЙН ДААТГАЛ** | | | | | |
| **2.3. Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | |
| 11 | 2.3.1. Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлнэ | Иргэдэд нийгмийн даатгалын тусламж үйлчилгээний талаар мэдээ мэдээлэл хүргэх | хамрагдсан иргэдийн хувь | 50% | Малчин шинээр 15, СДДаатгалд шинээр 14 0-3 настай хүүхдээ харж буй эх-4 даатгуулагч шинээр хамруулсан ба нийт 33 даатгуулагч шинээр СДДаатгалд хамруулсаж нтйи 118 даатгуулагчтай СДДаатгалын гэрээ хийсэн. Хамрагдалт нэмэгдүүлэх цахим сургалтанд 12 ААНэгж байгууллагийн 33 иргэнийг хамруулсан. БИНХуралд 5 удаа оролцож 170 гаруй иргэнд НДХуулийн тухай олголт өгч СДДаатгалын гэрээ хийж ажиллсан. НДЕГазрын болон Хэнтий аймгийн НДГазрын фэйж хуудсанд нийтэлсэн Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаарх шторк, постер, постуудыг цахим хуудсанд тухай бүр нийтэлсэн. 30 гаруй төрлийн нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг сумын 2000-5000 гишүүнтэй 4 грүппрүү 197 удаа шэйрлэсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **БИЕИЙН ТАМИР, СПОРТ** | | | | | |
| **2.4. Биеийн тамир, спортын хүртээмжийг сайжруулж, иргэдийн бие бялдрын боловсрол"-ыг дээшлүүлнэ.** | | | | | |
| 12 | 2.4.1. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, хөдөлгөөнт дасгал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ. | 2.4.1.1. Төрийн албан хаагч ААНэгжүүд болон багийн иргэдийн дунд спортын наадам зохион байгуулна . | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2 жилд 1 удаа | Төрийн албан хаагч ААНэгжүүд болон багийн иргэдийн дунд спортын наадам<br>-Сумын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд 11 багийн 84 иргэнийг,<br>-Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл Хэнтийчүүд аяны хүрээнд 352 (давхардсан тоогоор) иргэнийг,<br>-Сумын аварга шалгаруулах Дартсын тэмцээнийг зохион байгуулж 38 иргэнийг хамруулсан.<br>-Спортын арга хэмжээнд 2025 оны байдлаар 20 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 1180 иргэн хамрагдсан.Аймаг бүсийн чанартай үндэсний болон бусад спортын тэмцээнд давхардсан тоогоор 250 иргэд болон хүүхдүүд хамрагдсан. |
| | | 2.4.1.2. Иргэдийн биеийн тамираар хичээллэх , эрүүл зан үйлийг дэмжинэ. | | | Иргэдийн биеийн тамираар хичээллэх эрүүл зан үйлийг дэмжих зорилгоор Мөрөн фитнесс клубыг байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Мөн Идэвхтэй хөдөлгөөн – Эрүүл Хэнтийчүүд аянд нэгдэж идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортын тэмцээн уралдаануудыг иргэд, албан хаагч нарын дунд зохион байгууллаа. |
| 13 | 2.4.2. Өсвөр, залуучуудын шигшээ багийг дэмжин ажиллана. | 2.4.2.1. Шаардлагатай багш дасгалжуулагч боловсон хүчнээр хангана. | Секц дугуйланд хамрагдсан хүүхдийн тоо | 0 | ЕБСургуулийн сурагчдын дунд ЖУДО, САМБО, Үндэсний бөх, гар бөмбөг, Шатар, даам гэсэн төрөлүүдээр секц дугуйлан хичээллэж давхардсан тоогоор 130 гаруй хүүхэд хамрагдан хичээллэж байна. |
| | | 2.4.2.2. Өсвөр залуучуудын шигшээ багийг дэмжин ажиллана. | Дэмжсэн багийн тоо | Өсвөр, залуучуудын шигшээ багийг дэмжиж ажилладаг | “Алтан цом-2025” арга хэмжээнд сум орон нутагаа төлөөлөн оролцож байгаа залуучуудаа 2,0 сая төгрөгийн,<br>D лиг сагсан бөмбөгийн тэмцээнд Мөрөн сумаас оролцсон баг тамирчдад 2,0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлж ажилласан.<br>Шагайн харвааны тэмцээнд оролцож буй баг тамирчдад 350,000 төгрөгийн дэмжлэг |
| 14 | 2.4.3. Үндэсний спорт болон спортын их наадам, тэмцээн уралдаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж дэмжиж ажиллана. | | Үндэсний спортын төрлөөр дэмжлэг үзүүлсэн тэмцээн | Дэмжиж ажилладаг | Спортын арга хэмжээнд 2025 оны байдлаар 20 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 1180 иргэн хамрагдсан.Аймаг бүсийн чанартай үндэсний болон бусад спортын тэмцээнд давхардсан тоогоор 250 иргэд болон хүүхдүүд хамрагдсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | уралдааны тоо | | |
| **БОЛОВСРОЛ** | | | | | |
| **2.5.Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан тэгш хүртээмжтэй оролцоог дэмжин, сургалтын орчныг сайжруулж, сургалтын чанарыг нэмэгдүүлнэ.** | | | | | |
| 16 | 2.5.2. Дэвшилтэт технологийг ашилаж цахим сургалтын орчныг нэмэгдүүлнэ | 2.5.2.1. СӨБ-н багш нарыг интерактив хичээлийг бэлтгэх сургалтанд хамруулж, хичээлд ашиглаглаж хэвшүүлэх | цахим хичээлийн тоо | 1 | - Бүх багш нар цахим сургалтыг орж, дасгал даалгавар бэлдсэн.<br>- 2025 онд цахим интерактив хичээл, дасгал 12 ш<br>- "Таблеттай багш" хөтөлбөрийн 10-с доошгүй агуулгаар цахим интерактив 9ш<br>Хичээл 5ш бэлтгэн анги бүлэгт ажиллуулсан.<br>- Багш Б.Золзаяа бүсийн 8 цэцэрлэгийн 85 багшид " Интерактив дасгал даалгавар хэрхэн боловсруулах" сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан. |
| | | 2.5.2.2 Сургуулийн интернэтийн орчинг сайжруулна | Сургуулийн интернэтийн орчин сайжирч цахим танхимтай болсон байна. | | 4 хүүхэд тутамд 1 компьютер ноогдож байна. Компьютерийн тоо хүрэлцээтэй. ЭДҮТЭН ПРИЙСОН хичээл ордог 2 танхимтай. Цахим худалдан авалтаар иж бүрэн утасгүй сүлжээтэй болж дотоод сүлжээ болон интернэтийн орчин сайжирсан. Дотуур байр иж бүрэн интернэтэд холбогдсон. 30 таблет зэрэг цэнэглэх хүчин чадал бүхий таблет цэнэглэгч 6.500.000 төгрөгийн цахим худалдан авалт хийсэн. |
| 17 | 2.5.3. Багш нарын мэргэшил, чадавхыг сайжруулна | 5 болон 10 жилийн үндсэн сургалтанд хамруулах. Гадаадад богино хугацааны сургалтанд хамруулах | багш нарыг сургалтанд хмаруулсан байна. | 0 | Үндсэн 5 жилийн сургалтад Биеийн тамирын багш-1, 10 жилийн сургалтад Математикийн багш -1 хамрагдав.<br> 5 жилийн үндсэн сургалтанд Б.Золзаяа багш хамрагдсан.<br> Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний зөвлөмж арга зүйн сургалт 2 удаа / багш, удирдах ажилтнуудад/<br> ARTA системийг нэвтрүүлэх сургалт<br> ТАЗ-өөс зохион байгуулж байгаа цахим сургалтууд<br> ГХУССЗ-өөс зохион байгуулсан сургалт<br> Архив бичиг хэргийн стандарт, архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам сургалтууд<br>- Монгол бичгийн сургалт гэх мэт сургалтуудад хамрагдсан. |
| 18 | 2.5.4. ЕБС, дотуур байр, СӨБ-ийн хоол үйлдвэрлэл, | 2.5.4.1. СӨБ-ын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар | хамрагдсан сургалтын | | Хүүхдийн хоолны шим тэжээл, нэр төрлийг олшруулах тал дээр анхаарч менюд өөрчлөлт оруулсан. 7 хоногт 2 удаа иж бүрдэл, 7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна | хүртээмжийг сайжруулна. | тоо, Хоолны нэр төрөл | | буюу 14 хоногт 1 удаа сүү болон цагаан идээ, чацаргана, үхрийн нүд, үзэмний шүүс зэргийг өгч байна.<br>- 7 хоногт 3 удаа тогооч нар өөрсдөө хийсэн нарийн боовыг өгдөг.<br>- Хүнсний агуулахын тавиурыг шинээр хийж, хүнс хадгалах зориулалтын савнуудыг ашиглаж байна |
| | | 2.5.4.2 Тоног төхөөрөмжөөр хангана | | | Сургуулийн хоолны газарт<br>- Махны машин 1.000.000<br>- Мексер 100.000<br>- Хэмжигч багаж 200.000<br>- Гал тогооны ажилчдын хувцсанд 370.000 төгрөг зарцуулав.<br>Нийт зарцуулсан хөрөнгө- 1.670.000 төгрөг |
| | | 2.5.4.3 Боловсон хүчнээр хангана. | 2 боловсон хүчнээр хангагдсан байна. | угаагч, бэлтгэгч хоол зүйч | Хоол зүйч 1, угаагч бэлтгэгч 1 ажилтнуудыг авч боловсон хүчний хангалт 100% |
| 19 | 2.5.5. Боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулна | 2.5.5.1. Цэцэрлэгийн гадна тоглоомын талбай, дотор засварын ажлыг шийдвэрлэнэ | Гүйцэтгэлээр | Тоглоомын талбай болон дотор засвар 2013 оноос хойш засвар хийгдээгүй | ОНХС-аар " Архалдай ХХК" цэцэрлэгийн гадна тоглоомын талбай, дотор засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Гадна болон дотор 3 бүлэг, гал тогооны хаалгыг солих<br>- Бүлгүүдийн хана, таазанд замаск хийж эмульсдэх<br>- 1,2 давхрын коридорт хулсан хавтан хийх гэх мэт ажлуудыг хийсэн.<br><br>- Гадна 3 гулсууртай тоглоом угсрах<br>- Цонхны жийргэвч резин солих гэсэн ажлуудыг огт хийгээгүй. / төсөв мөнгөтэй холбоотой/<br>Урсгал засвар дээрээс 1,2 давхрын гэрэл мөн коридорыг бүтэн зузаан хулдаасаар хулдаасалсан. |
| | | 2.5.5.2. ЕБСургуулийн спорт заал, дотуур байрны засварын ажлыг хийнэ | Гүйцэтгэлээр | Ашиглалтанд орсоноос хойш засварт ороогүй | Орон нутгийн хөгжлийн сангийн 105 сая төгрөгийн санхүүжилтээр спорт заалны их засвар хийсэн.<br>Сургуулийн спорт зааланд орон нутгийн эрсдэлийн сангаас 13.000.000 төгрөгөөр дотор ханыг акустик хавтангаар бүрэх, дээвэр ханын сийгэлтийг засварлах ажлыг хийв. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 105 сая төгрөгийн өртөгтэй спорт заалны их засвар хийсэн.<br>ҮР ДҮН: Сурагчдын биеийн тамирын хичээл, сонгон дугуйлан явуулах тав тухтай орчин бүрдсэн. Халаалт хэвийн болсон. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | 2.5.6. Багш, ажилчдын нийгмийн баталгааг хангаж, боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллах боломжийг хангана | 2.5.6.1. Гадаадад богино хугацааны сургалтанд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ | Гүйцэтгэлээр | 1 багшид дэмжлэг үзүүлсэн | Одоогоор байхгүй |
| | | 2.5.6.2 Гүйцэтгэлийн үнэлгээгээр 1 дүгээр түвшинд шалгагдсан багш нарт дэмжлэг үзүүлнэ | 12 багш | 6 багш | Гүйцэтгэлийн үнэлгээнд амжилттай шалгагдсан 3 багшид сумын засаг дарга тус бүр 200.000 мянган төгрөгөөр урамшуулсан.<br>Аймгийн тэргүүлэх зэрэгтэй багш нарын ур чадварын уралдаанд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн 1 багш, аймгийн байгалийн ухааны шилдэг секцээр шалгарч шагналт байр эзэлсэн 3 багш нийт 4 багшид үндсэн цалингийн 20%-иар 1 сар урамшуулсан.<br>2025 оны 1-9 сар хүртлэх хугацаанд гүйцэтгэлийн үнэлгээний 8 багш нарт нийт 18.683.400 төгрөг олгосон байна.<br>Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал нийт 11 багшид 2.827,000 төгрөг олгосон байна. Байгууллагын үнэлгээний урамшуулалын 1.500.000 төгрөгийг " Охидын өрөө" тохижуулахад зарцуулав.<br>**СӨБ:** Гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-р түвшинд үнэлэгдсэн багш Б.Золзаяад урамшуулал олгосон.<br>- Багш нарын ажиллах таатай орчин нөхцөл нөхцлийг ханган ажиллаж байна.<br>- Хүүхдийн өрөө буюу жижүүрийн өрөөг амрах өрөө болгон тохижуулсан. |
| **ЭРҮҮЛ МЭНД** | | | | | |
| **2.6.Нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | |
| 21 | 2.6.2. Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулна | 2.6.2.1. 0-5 хүртэлх насны хүүхдүүд, ээжүүдийн гэрийн эргэлтийг тогтмолжуулж, бага насны хүүхдүүдийг осол гэмтлээс сэргийлэх ажлыг зохион байгуулна | Гэрийн эргэлтийг 60%-д хүргэнэ | Хүүхдийн гэрийн эргэлт 20% | Сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд ЭМТөв нь сар бүр 0-5 насны хүүхдүүдийг графикийн дагуу эргэлт хийж эцэг эх, асран хамгаалагч нарт ахуйн хүрээний осол гэмтлээс сэргийлэх, томуу томуу төст өвчин, гар хөл амны өвчин, гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан. 2,3,4,5,7,9,10,11 дүгээр саруудад давхардсан тоогоор 0-5 хүртэлх насны 213 хүүхэд буюу зорилтот насны 109 хүүхдүүд байгаагаас 100% гэрийн эргэлт хийгдсэн байна. 2025 онд 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлгүй ажилласан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.6.2.2. 16 хүртэлх насны хүүхдүүдэд зуны сааман сувилал ажиллуулж чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулна | Жил бүр 10-14 хоног сувилал ажиллуулах | сааман сувилал ажиллаж байгаагүй | 2025 оны 7 дугаар сарын 21ны өдрөөс 27ны өдрүүдийн хооронд Мөрөн сумын ЭМТөв, Мөрөн сумын ЗДТГ, Мөрөн сумын 4-р багийн малчин Л.Баттуяагийн гэр бүлтэй хамтран 7 хоногийн хугацаанд Гүүний сааман өдрийн сувиллыг ажиллуулсан. Тус үйл ажиллагааны хүрээнд мөрөн сумын харъяаллын 0-16 хүртэлх насны хүүхдүүдийг чийрэгжүүлэх, амьсгалын тогтолцооны өвчлөл хүндрэл, чийг бам өвчнөөс сэргийлэх, саам, шар сүүн шавшлага хийх,эмчилгээний хоолоор сувилах, элсэн шарлага хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. 7 хоногийн хугацаанд 230 хүүхэд буюу зорилтот насны 409 хүүхдээс 56.2%-ийг хамруулсан. |
| 22 | 2.6.3. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ. | 2.6.3.1. УАУ-ны арга зүйчийг чадавхжуулах богино хугацааны сургалтанд хамруулж, УАУ сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрөлийг нэмэгдүүлнэ. | УАУ, СЗасах тусламж үйлчилгээний нэр төрөлийг 10-12 нэр төрөл болгож нэмэгдүүлэх | УАУ, СЗасах 7 нэр төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа. | Монголын нэгдмэл АУ-ны нийгэмлэгээс 21 аймагт уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх , түгээн дэлгэрүүлэх, нөлөөллийн багуудыг байгуулах ажлын хүрээнд 2025.11.17ны өдөр уламжлалтын эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг цахимаар зохион байгуулсан. Тус сургалтанд ЭМТөвийн уламжлалт анагаах ухааны сувилахуйн арга зүйч Д.Галхүү хамрагдсан. |
| 23 | 2.6.4. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх. | 2.6.4.1. антибиотикийн хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулж антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх | Антибиотик эмчилгээ хэрэглэх тохиолдол бүрийг оношилгоо, шинжилгээнд тулгуурлаж хийх | Амбулаторийн үзлэгээр антибиотик эмчилгээг бичихэд шинжилгээ үндэслэдэггүй. | Бичил биетний эсрэг эмийн зарцуулалтыг хянах ажлын хүрээнд Мөрөн сумын ЭМТөвд амбулаториор үзүүлж буй иргэд болон хэвтүүлэн эмчлэх, өдрийн эмчилгээнд хамрагдаж буй иргэдэд Цусны ерөнхий шинжилгээг хийж шинжилгээний заалтыг үндэслэн зайлшгүй тохиолдолд антибиотик эмчилгээг бичих, тарих, уулгах арга хэмжээг авч байна.Мөн антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор ЭМТөвийн ажилчдад дотоодын сургалтыг 1 удаа, Иргэдэд танхимын сургалтыг 1 удаа, Хэвтэн эмчлүүлж буй болон ЭМТөвөөр үйлчлүүлж буй иргэдэд Эмч, сувилагч нар тогтмол зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлага тарааж байна. Дотоодын сургалтанд 15 ажилтан, Иргэдэд зориулсан танхимын сургалтанд 39 иргэн, ганцаарчилсан зөвлөгөөг давхардсан тоогоор 725 иргэнд буюу хүн амын 39.2%-д хүрч ажилласан байна. |
| | | 2.6.4.2. Цахим жор бичилтийг тогтмолжуулж, Жоргүй | цаасан жорыг бууруулж цахимаар | Жортой, жоргүй олгодог | Цахим жор бичилт тогтмолжсон хэрэгжилт 100% байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | олгодог эмийн хэрэглээг бууруулах ажлыг зохион байгуулна. | жор бичих ажлыг тогтмолжуулах | эмийг иргэд эмчийн заавар, зөвшөөрлийн дагуу авч хэвшсэн байх | |
| 24 | 2.6.5. Цахим эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж, алсын зайн оношилгоо, шинжилгээг тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ | 2.6.5.1. Алсын зайн технологи ашиглаж 2,3 дугаар шатлалын ЭМБайгууллагаас зөвлөгөө авч оношилгоо эмчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэх | Телемидецин ашиглан 2,3-р шатлалын эмнэлгээс шаардлагатай тохиолдолд зөвлөгөө авах | 2-р шатлалын эмнэлгээс Хүүхэд, Гэмтлийн эмчийн зөвлөгөө авдаг | Телемидецины хэрэгжилт тогтмолжоогүй боловч Шаардлагатай тохиолдолд АНЭ-ийн мэргэжлийн эмч нараас утсаар зөвлөгөө авч ажиллаж байна. 2025 оны байдлаар АНЭ-ийн хүүхдийн зөвлөх эмчээс 2 удаа, Гэмтэл согог засалын эмчээс 1 удаа, мэдрэлийн эмгэг судлалын эмчээс 1 удаа,Хавдар судлалын эмчээс 1 удаа утсаар зөвлөгөө авч ажилласан. Үүнээс 2р шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ шаардлагатай хүүхэд 1, мэдрэлийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ шаардлагатай 1 иргэнийг холбогдох журмын дагуу АНЭ-т аюулгүй тээвэрлэн шилжүүлсэн. |
| 25 | 2.6.6. Эмч, мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг сайжруулж, тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангана. | 2.6.6.1. Орон нутагт ажиллахаар ирсэн эмч ажилчдыг малжуулах, шинээр газар авахад дэмжлэг үзүүлэх, түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэх | ЭМБАйгууллагын ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлж, малжуулах | түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлж байгаагүй, | 2025 онд төсвийн хэмнэлт хийгдэж цалин хөлс, хүнс, эм эмнэлгийн хэрэгслийн төсвөөс бусад төсвийн зарцуулах эрхийг ЭМЯ-аас хязгаарласан. Ийм учир 2026 оны эхний улиралд төсөвтөө багтаан энгийн галлагаатай сууцанд амьдардаг ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэхээр төлөвлөж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.6.6.2. Эмч эмнэлгийн ажилчдыг 2,3р шатлалын төр, хувийн хэвшлийн эмнэлэгүүдтэй туршлага судлах ажлыг зохион байгуулах | 2,3 дугаар шатлалын эмнэлэгт туршлага судалж эмчилгээ үйлчилгээнд шнэ санаа, оновчтой бүтээлийг нэврүүлэх | 2,3 дугаар шатлалын эмнэлэгт туршлага судалж байгаагүй | 2025 оны 3 дугаар сарын 17-22 өдрүүдийн хооронд МСЭХМолбооноос санаачлан Удирдлагын академитай хамтран 40 цагийн ''Сумын Эрүүл мэндийн төвиийн удирдлагын хөгжил'' сэдэвт сургалтыг танхимаар зохион байгуулсан ба дээрх сургалтанд эрхлэгч эмч хамрагдсан. Мөн ЭХЭМҮТ, ЭМЯ, ЭМГ-н хамтарсан чадавхжуулах танхимын 4 удаагийн сургалтанд 10 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. |
| 26 | 2.6.7. Эрүүл мэндийн байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ. | 2.6.7.1. Алсын зайн мобайл технологийг нэвтрүүлж малчны хотонд оношилгоо шинжилгээг газар дээр нь хийх нөхцөлөөр хангах | мобайл технологито й болох | мобайл технологиг үй | Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс жил бүр зохион байгуулдаг Мэргэшүүлэх сургалтын намрын элсэлтэнд дүрс оношилгооны баримжаа олгох богино хугацааны сургалтанд 1 их эмч хамруулахаар төлөвлөж байсан боловч 2025 онд элсэлт аваагүй тул 2026 онд сургахаар төлөвлөөд байна. |
| 27 | 2.6.8. Урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, эрт илрүүлгийг жил бүр тогтмол зохион байгуулна. | 2.6.8.1. Зорилтот насны иргэдийг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх ажлыг багын дарга нартай хамтран тогтмол зохион байгуулах | зорилтот насны иргэдийн 23% хамрагдсан | зорилтот насны иргэдийн 45 %-ийг хамруулах | Өвчлөлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Эмэгтэйчүүдийн умайн хүзүүний хавдрыг илрүүлэх эсийн шинжилгээнд хамрагдах зорилтот насны 138 иргэнээс 51 иргэнийг буюу 36.9%-г хамруулсан. Хөхний хавдар илрүүлэх зорилтот насны 325 иргэнээс 135 иргэнийг буюу 41.5%-г хамруулсан байна. Мөн артерийн даралт ихсэлт, Чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих насны 1295 иргэнээс 798 иргэн буюу 61.6% хамрагдсан байна. |
| 28 | 2.6.9. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | 2.6.9.1. Шүд амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хангах, Гурвалсан гэрээ байгуулах, шүд амны | шүд амны хөндийн тусламж үйлчилгээг ЭМД-аар гэрээ байгуулж бие даан | шүд анмны өхндийн тусламж үйлчилгээг бие даан үзүүлдэггү й | Эрүүл мэндийн газар, аймгийн Танан цагаан шүд шүдний эмнэлэг, мөрөн сумын ЭМТөв гурвалсан гэрээ байгуулан 2025 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 7 настай буюу 1-р ангийн 10 хүүхдэд шүд амны хөндийн үзлэг хийж, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 1-р ангийн сурагчдыг бүрэн хамруулсан. Мөн 10 дугаар сард УБ хотын toothcare шүдний эмнэлэгтэй хамтран цэцэрлэг, сургуулийн 85 хүүхдэд амны хөндийн нарийвчилсан үзлэг хийж эрүүл шүдтэй болон өвчлөлтэй шүдтэй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаж эрүүл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тусламж үйлчилгээг үзүүлэх | үзүүлдэг болох | | мэндийн газарт хүргүүлсэн. 5 дугаар сард АНЭ-ийн ариутгалын тасагтай хамтран ариутгагч сувилагчийг чадавхжуулах ажлын байрны сургалтыг 7 хоногийн хугацаанд зохион байгуулж ариутгагчыг чадавхжуулсан. Мөн 6 дугаар сард ХӨСҮТ-өөс ариутгалын ажилчдыг чадавхжуулах 2 өдрийн сургалтыг аймгийн ЭМГазартай хамтран зохион байгуулсан ба тус сургалтанд ЭМТ-ийн ариутгагч сувилагч хамрагдаж ариутгалын сертификаттай болсон. |
| | | 2.6.9.2. Шүд амны хөндийг эрүүлжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт суратлчилгаар үе шаттай зохион байгуулах | Шүд амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа тогтмолжоогүй | үе шаттай тогтмол зохион байгуулдаг болох | Эрүүл мэндийн газар, аймгийн Танан цагаан шүд шүдний эмнэлэг, мөрөн сумын ЭМТөв гурвалсан гэрээ байгуулан 2025 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 7 настай буюу 1-р ангийн 10 хүүхдэд шүд амны хөндийн үзлэг хийж, эрүүлжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан. Мөн дээрх үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн шүдний ОО,сойз сонголтыг хэрхэн хийх, хүүхдийн шүдийг хэрхэн зөв угаах талаар эцэг эх асран хамгаалагч нарт сургалт хийж, зөвлөгөө өгсөн. Сургалтанд 1-р ангийн 10 хүүхэд, 12 асран хамгаалагч хамрагдсан. |
| **ОРОН СУУЦ, ДЭД БҮТЭЦ** | | | | | |
| 29 | 2.7.3. Суурин газрын үерийн эрсдэлийг бууруулна | | Үерийн даланг сэргээн засварлах | Үерийн далантай | Суурин газрын үерийн эрсдэлийг бууруулах үерийн даланг нөхөн сэргээх чиглэлээр 1.5 сая төгрөгийн хөрөнгөөр үерийн даланг сэргээн засварласан |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | |
| **Санхүү, хяналт** | | | | | |
| 30 | 3.1. Төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод хяналтын үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. | 3.1.1 Шилэн дансны цахим хуудсаар байгууллагын төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана. | Төсөвт байгууллагууд болон сангуудын мэдээллийг 100% бүрэн мэдээлсэн байна. | Төсөвт байгууллагууд болон сангуудын мэдээллийг 100% мэдээлсэн. | Төсөвт байгууллагууд болон сангуудын мэдээллийг шилэн дансаар 100% бүрэн мэдээлсэн. Байгууллагын шилэн дансны мэдээлэлд сумын ИТХ-тай хамтарч 2 удаа хяналт шалгалт явуулсан. |
| | | 3.1.2. Санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулж, дотоод хяналт шалгалтын | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд | Байгууллагын санхүүгийн үйл | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх удирдамжийг батлуулан сумын ИТХ-тай хамтран Дотоод хяналт 1 удаа хийсэн байна. УБ-хотод СИТИ-с сургалтанд төсөвт байгууллагын 5 нябог хамруулсан байна |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
